

**“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025-02-17

Улаанбаатар хот

ДУГААР №05/2025

“Улаанбаатар хивс” ХК-ийн 2024 оны үйлдвэрлэл, үйл ажиллагааны үр дүн, Монгол улсын Компанийн тухай хуулийн 46, 47-р зүйлд тусгагдсан ноогдол ашиг хуваарилах нөхцөл болон ТУЗ-ийн 2025 оны 02-р сарын 17-ны өдрийн хурлаар хэлэлцсэн асуудал, гарсан санал, шүүмжлэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2024 оны үйлдвэрлэл, үйл ажиллагааны үр дүн гарсантай холбогдуулан компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 2000 төгрөгийн ноогдол ашиг хуваарилсугай.
2. Ноогдол ашиг авах хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2025 оны 03-р сарын 14-ний /Баасан гариг/ өдрөөр тогтоосугай.
3. Компанийн ноогдол ашгийг СЗХ-ны холбогдох журмын дагуу нийт хувьцаа эзэмшигчдэд 2025 оны 06-р сард багтаан олгож, үр дүнг тайлагнахыг компанийн удирдлага, санхүүд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ЗОРИГТ